

МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

З.Баасанжав

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Ухааны Их Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Монголын боловсролын салбарт шинэчлэл хийх болсон шалтгааныг Монголын нийгмийн хөгжил, өнгөрсөн тогтолцооны үеийн боловсролын салбарын сул талууд, глобальчлалын өнөөгийн шинж хандлагатай холбон тайлбарласан байна. Манай орны боловсролын салбарт хийгдэж буй шинэчлэлийн үйл явцыг боловсролын салбарын бүтэц тогтолцооны, зорилгын агуулгын, арга зүй-технологийн, эрх зүйн орчны, эдийн засгийн, удирдлагын гэх мэт чиглэлүүдээр бүлэглэн авч үзжээ.

Түлхүүр үг: Боловсрол, шинэчлэл, академик, прагматик, сургалтын зорилго, агуулга, арга зүй, технологи, эрх зүй

Монголын нийгмийг хамарсан шинэчлэл өөрчлөлтийн үйл явцаас боловсролын салбар ангид байгаагүй билээ. Манай орны боловсролын салбарт өөрчлөлт, шинэчлэл хийх болсон нь хэд хэдэн шалтгаантай хэмээн үзэж болох авай. Эдгээрийг гурван үндсэн бүлэг болгон авч үзэж болох талтай. Тухайлваас:

- Монголын нийгмийг бүхэлд нь хамарсан өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой бүлэг шалтгаан байна. 1980-аад оны дунд үеэс эхэлсэн хуарангийн социализмаас иргэний хүмүүнлэг, ардчилсан нийгэмд шилжих үйл явц нь нийгмийн өөрийн мөн чанараас хамааран бүхий л салбарыг хамран, түүний дотор боловсролын салбарт ч явагдаж байна.
- Өмнөх тогтолцооны үеийн боловсролын системийн сул талуудтай холбоотой гэж хэлж болно. Социализмын гэгдэж байсан үеийн боловсролын систем нь бүх нийтийн үнэ төлбөргүй, бүх нийтээр хамран сурган боломж бий болсон, орчин үеийн боловсролын бүхэл бүтэн тогтолцоо бүрэлдэн бий болсон зэрэг давуу талууд байсан авч боловсролын агуулга үзэл сурталжсан, уламжлалаасаа ихээхэн хөндийрч,
- гаднын (ЗХУ-ын) жишгийг хуулбарласан, сургалт нь академик шинж зонхилсон, амьдрал, практикаас хөндий байсан, хүний хөгжлийг хайрцагласан, бүтээлч сэтгэлгээг хязгаарласан, хэлбэрдэх, компаничлах үйл зонхилсон зэрэг сул талууд бий болсон нь шинэчлэл хийх шаардлагыг агуулж байлаа.
- Глобальчлалын өнөөгийн үндсэн шинж хандлагатай холбоотой бүлэг шалтгаан байна. Орчин үед глобаль боловсролын тухай асуудал хурцаар дэвшигдэн гарч ирж байна. Энд юуны өмнө суралцагчдад олгох түгээмэл гадаад хэл, компьютерийн боловсрол, энх тайваныг эрхэмлэх үзэл, хөрвөх чадвар, бүтээлч сэтгэлгээний асуудал эн тэргүүнээ хамаарч байна.

Манай боловсролын салбарт хийгдэж байгаа шинэчлэлийг дараах хэдэн хэсэгт хуваан үзэж болох байна.

Боловсролын салбарын бүтэц тогтолцооны шинэчлэл. Энд эн тэргүүнээ төрийн өмчийн монополь задарч боловсролын салбарт хувийн өмчийн байгууллагууд байгуулагдаж эхэлснийг дурьдваас зохино. Хувийн хэвшлийн цэцэрлэг, бага, дунд болон коллеж, дээд сургуулиуд байгуулагдлаа. Ингэснээр төрийн нуруун дээрх ачааллыг хөнгөлөх, эл салбарт өрсөлдөөнийг бий болгох боломжийг бүрдүүлэх боломжийг нээсэн

байна.

Тэрчлэн дунд боловсрол өнөөгийн дэлхий нийтийн жишгийг даган 2004-2005 оны хичээлийн жилээс 11 жилийн тогтолцоонд шилжиж, улмаар 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжих шилжилт хийх гэж байна. Манай орны ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоо нь 6 настай хүүхдийг анхлан сургуульд авч сургах ба 6+3+3 гэсэн бүтэцтэй байхаар төлөвлөгдсөн байна.

Дээд боловсролын салбар дээд боловсролын дипломын (90 орчим багц цаг), бакалаврын (өмнөх шатлалыг оролцуулаад 120 багц цаг), магистрын (өмнөх шатлалын хамт 150 багц цаг), докторын (магистрын сургалтын багц цагийг оролцуулаад 210 багц цаг цуглуулах) гэсэн шаталсан сургалтанд шилжлээ. 1993 онд МУИС анх магистрын сургалтыг нээн хичээллүүлж 13 хүнийг төгсгөсөн байна.

Эрх зүйн орчны шинэчлэл. Манай боловсролын салбарыг харилцааг эрх баригч намын тогтоол шийдвэр, төрийн захиргааны байгууллагаас гаргасан дүрэм журам зэрэг баримт бичгээр зохицуулан ирсэн байна. Харин 1963 онд "Сургууль амьдралын холбоог бэхжүүлэх тухай хууль" анхлан гарч эрх зүйн үндэс бүрэлдэх алхам хийгдсэн байна. Улмаар "Ардын боловсролын хууль батлагдан гарч 1990-ээд оны хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байлаа.

1992 оны Монгол улсын шинэ Үндсэн хуулинд "Монгол улсын иргэн...сурч боловсрох эрхтэй"¹, "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль ажиллуулж болно."², "Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг"³ гэж заажээ. Мөн 1991 онд "БНМАУ-ын Боловсролын хууль" 1995 онд "Боловсролын тухай", "Бага дунд боловсролын тухай", "Дээд боловсролын тухай" Монгол улсын боловсролын багц хуулийг УИХ батлан гаргасан ба 2002, 2006 онуудад өөрчлөлт оруулжээ. Дараа нь "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай", "Сургуулийн өмнөх боловсролын тухай" Монгол улсын хууль батлагджээ.

Монголын боловсролын зорилго шинэчлэгдэн өөрчлөгдөж байна. Боловсролын супер тогтолцоог бүрдүүлэгч элементүүдээр нь бүхэллэг болгон авч үзвээс орц-явц-гарц гэсэн гурван хэсэгт хуваан үзэж болох ба боловсролын зорилго нь түүний орц хэсэгт хамаарах авай.

Боловсролын зорилгыг манай зарим судлаачид нийгмийн, сургах зүйн сэтгэл зүйн гэсэн 3 түвшинд хуваасан⁴ байдагт бүрнээ тал өгч болох юм. Нийгмийн түвшинд боловсролын зорилго нь түүхэн цаг үеийн шинж төлөв, хандлагаас хамааран тухайн үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагаас хамааран хүнийг төлөвшүүлэх нийгмийн захиалгыг илэрхийлэн өөрчлөгдсөөр ирсэн байна. Тухайлвал XIII-XIV зууны үед монголчууд цэргийн хэргийн эрдэмд суралцсан, харвах намнах цэц мэргэн, зориг хатуужилтай хүнийг төлөвшүүлэхийг гол зорилго болгож байсан бол Дөчин дөрвөн хоёрын үе буюу бурхны шашны гутгаар дэлгэрэлтийн үеэс шашны боловсролыг чухалчлан үзэж байлаа. Харин XX зуунаас маркст-ленинч үзэл онолыг эзэмшсэн социализм-коммунизмын үйл хэрэгт чин үнэнч хүмүүс бэлтгэхийг боловсролын гол зорилго болгож байв. 1982 онд батлагдсан "БНМАУ-ын Ардын боловсролын хууль"-нд сургуулийн үндсэн зорилтыг "Залуу үеийнхэнд ертөнцийг үзэх марксист-ленинст үзэл төлөвшүүлэн тэднийг

¹ Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992.

² Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992.

³ Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992.

⁴ У.Дод нар. Сургалтын технологийн инвариант загвар. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. "Боловсрол судлал" №1(140), 1998, 22 дахь тал

пролетарийн интернациональч социалист эх оронч эх орноо хамгаалахад бэлэн байх үзэл санаагаар хүмүүжүүлэх⁵”, “сурагчдыг коммунист ёс суртахууны эрхэм нандин ча нартай болгон хүмүүжүүлэх⁶” гэж тодорхойлсон байдаг.

Глобальчлалын өнөөгийн үед эрин үедээ нийцэн амьдрах, ажиллах чадвартай, глобаль боловсролтой иргэнийг төлөвшүүлэхийг нийгмийн хэрэгцээ шаардлага дэвшүүлэн гаргаж ирсэн билээ.

“Боловсролын тухай” Монгол улсын хуулинд “Монгол улсын боловсролын гол зорилго нь иргэнийг ёс суртахуун бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино⁷” гэж тодорхойлсон байна.

Боловсролын зорилго нь сургах зүйн түвшинд хүнийг иргэншүүлэх, нийгэмшүүлэх, хүмүүнлэг ардчилсан үзэл бодол төлөвшүүлэх, хөрвөх чадвар бүхий боловсролтой иргэнийг өөрөөр хэлбэл соёлт хүнийг төлөвшүүлэх асуудлыг хамарч байна.

Боловсролын агуулгын шинэчлэл. Энэ чиглэлээр хийгдэж байгаа шинэчлэл нь юуны өмнө боловсролын агуулгыг улс төржсөн, үзэл сурталжсан байдлаас гаргах, академик хийгээд прагматик шинжийг зохистой хослуулах, хувь хүний болон нийгмийн хэрэгцээ шаардлагыг зөв хослуулах зэрэгт чиглэгдэж байна. Боловсролын агуулгын шинэчлэлд анхаарал татаж буй нэг асуудал нь түүний академик болон прагматик шинжийн харьцааны асуудал юм. Өнөөдөр зарим сургах зүйчид сургалтын агуулгын прагматик шинжид гол анхаарал хандуулж, түүний академик шинжийг үгүйсгэх тал зарим тохиолдолд ажиглагдах боллоо. Энэ нь сургалтын нэгэнт хүрсэн түвшинг бууруулах сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй билээ. Харин өнөөгийн нэгэнт хүрсэн агуулгын академик шинжийг бууруулахгүйгээр прагматик шинжийг нэмэгдүүлэх замаар зөв харьцаа тогтоох нь арга зүйн хувьд оновчтой юм. Өөрөөр хэлбэл энэ харьцааг тогтоох гурван хувилбар байна. Үүнд:

- Академик $\leq$ прагматик
- Академик $\geq$ прагматик
- Академик $\approx$ прагматик

Ерөнхий боловсролын агуулгыг 1998 онд агуулгын стандартаар тодорхойлж, улмаар 2004 онд агуулгын үлгэрчилсэн хүрээг боловсруулан БСШУЯ батлан гаргаж, түүнийг 2006 оны 8 дугаар сард дахин шинэчилсэн билээ. Одоо 12 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, боловсролын хөтөлбөрийг шинэчлэн тогтоох ажил хийгдэж байна.

Сургалтын арга зүй, технологийн шинэчлэл. Суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэгийг дамжуулах бус суралцагчдаар бүтээлгэх, бие даан суралцах, бүтээлчээр унших, бичих, ярих, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн сургалтын арга, арга барилыг нэвтрүүлэх, сургалтын технологийн багш-сурагч буюу объект-субъектийн харьцаанаас субъект-субъектийн харьцаанд шилжих, сургалт нь олон хувилбар, нээлттэй, ардчилсан байх замаар арга зүй технологийн шинэчлэл хийгдэж байна. Сүүлийн жилүүдэд сургалтын арга гэсэн энэхүү ойлголтын агуулга ихээхэн өргөжиж, зөвхөн багшийн заан сургах аргыг хамруулан үздэг үзэл үеэ өнгөрөөж, суралцагчдын сурах арга, сургах болон

⁵ БНМАУ. Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл. УБ., 1982, 486 дахь тал

⁶ Мөн тэнд

⁷ “Багш” сонин. 2002, №22, 23.

сурах үйлийн хамтарсан аргуудыг багтаан үзэж байна. Сургалтанд суралцагчдыг хүндэтгэх, тэдний нас бие сэтгэхүйн онцлог, хувийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх, суралцах боломжийг адил тэгш олгох, аливаа ялгарлан гадуурхах байдал гаргахгүй байх, хүмүүнлэг, ардчилсан ёс, шударга ёсыг дээдэлсэн, шинжлэх ухаанч байх зэрэг зарчмыг баримталж байна.

Боловсролын үнэлгээ дүгнэлтэнд шинэчлэл хийгдэж байна.

Суралцагчдын хөгжил төлөвшлийг үнэлж дүгнэхэд шинэчлэл хийх болсон нь боловсролын салбарт хийгдэж байгаа шинэчлэлтэй нягт холбоотой агаад эдүүгээгийн үе суралцагчдын хийгээд сургалтын байгууллагын өмнө шинэ шинэ шаардлага дэвшүүлэн тавьж байгаатай холбоотой билээ.

Сургалтын үр дүнг үнэлж дүгнэхийн гол утга учир нь боловсролын байгууллагын нийгэмд оруулж буй үнэт зүйл, суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийн түвшинг тодорхойлох, боловсролын стандартын хэрэгжилтийг илтгэх, сургалтын явцыг оншлох, суралцагчдын сурч боловсрох хүсэл эрмэлзлэл, танин мэдэх сонирхолыг хөгжүүлэх тэтгэн дэмжих зэрэгт оршино.

Өнгөрсөн тогтолцооны үеийн үнэлгээний онц, сайн дунд, муу, онцмуу гэсэн 5 баллын системийг 1990-ээд онд өөрчилж, үсгэн, тоон, онооны системийг бий болгосон нь дэлхий нийтийн жишигт ойртуулах гэсэн хэрэг байлаа. Монгол улсын Гэгээрлийн сайдын 1998 оны 259 дүгээр тушаалаар батлагдсан "ЕБС-ийн сурагчдын мэдлэг чадвар, төлөвшилтийг үнэлж дүгнэх үлгэрчилсэн журам"-аар үнэлгээг А-сурлагын дээд түвшин, В-дунджаас дээгүүр түвшин, С-дундаж түвшин, D-дунджаас доогуур түвшин, F-хангалтгүй доод түвшин гэсэн 5 түвшингээр үнэлэх болсны сацуу суралцагчийн чадварын төлөвшлийг гол шалгуур болгох, хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх, стандарт бус үнэлгээг жинхэнэ утгаар нь хэрэглэх боломжийг бүрдүүлж өгсөнөөрөө өмнөхөөс ялгаатай болсон юм.

2003 онд манай орны ерөнхий боловсролын сургуульд мөрдөх боловсролын стандартыг Монгол улсын СХЗ-ын газар батлан гаргасан ба энэ стандартын хүрээнд үнэлгээний стандартыг боловсруулан гаргаж мөрдөж байна.

Боловсролын үр дүнгийн асуудалд түүний чанарын тухай асуудал чухал байр суурь эзлэх авай. Өнгөрсөн тогтолцооны үед боловсролын чанарыг зөвхөн онц, сайн дүнгийн эзлэх хувиар тодорхойлж байлаа. Гэтэл эл асуудал өнөөдөр зарчмын өөр болж байна. Боловсролын үнэлгээ нь дэвшүүлэн тавьсан зорилтын хэрэгжилт, үр дүн хийгээд боловсролын чанарыг тодорхойлоход чиглэгдэх учиртай. Чанар хэмээх ойлголт нь нийтлэг агаад үйлдвэрлэл, бизнесийн хүрээнд нийтлэг хэрэглэгдэж буй ISO 9000-д "чанар бол шаардагдаж буй эрэлт хэрэгцээг хангахуйц бараа, үйлчилгээний цогц шинж бөгөөд зөвшилцөж тохирсон стандарт шаардлагаар тодорхойлогдоно" гэсэн байдаг. Үүнд тулгуурлан боловсролын чанар гэдэг нь суралцагч болон нийгмийн хэрэгцээг хангаж байгаа байдал, сэтгэл ханамж, төлөвлөсөн зорилго, зорилтын биелэлт юм. Боловсролын чанарын асуудал нь тухайн орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин түүх, соёлын уламжлал зэрэгтэй нягт холбоотой байдаг бөгөөд уг харилцаанд оролцогч хэрэглэгч, нийлүүлэгчийн хамтын хөдөлмөрийн үр дүн байдаг онцлогтой.

Сүүлийн жилүүдэд манай боловсролын байгууллагын системд байгууллагын хийгээд хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хэрэгжиж байна. Анхлан 1998-1999 оны хичээлийн жилд МИУС, МУБИС, ЭМШУИС, ШУТИС, ХУИС, ХААИС, СУИС зэрэг төрийн өмчийн, Отгонтэнгэр, Монгол бизнес, Орхон дээд сургууль, Улаанбаатар коллеж зэрэг төрийн өмчийн бус сургуулиуд байгууллагын магадлан итгэмжлэл амжилттай хийлгэсэн байна.

2008 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар Төрийн өмчийн дээд боловсролын байгууллага 27, Төрийн өмчийн бус дээд боловсролын байгууллага 54, төрийн өмчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 3 тус тус магадлан итгэмжлэгджээ. Харин 2003-2004 оны хичээлийн жилээс байгууллагын хоёр дахь магадлан итгэмжлэл эхэлсэн агаад одоогийн байдлаар төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 20 гаруй сургуулиуд үүнд хамрагдаад байна.

Тэрчлэн сургууль боловсролын ажилд төрийн хяналт хийх байгууллагын тогтолцоог шинэчлэсэн байна. 1991 онд Боловсролын мэргэжлийн хяналтын алба байгуулагдсан юм⁸. Уг албаны гол үүрэг нь Боловсрол, соёл шинжлэх ухааны салбарын талаарх хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийж зөрчил дутагдлыг арилгуулахад чиглэгдсэн байдаг. Улмаар улсын хэмжээний мэргэжлийн хяналтын газрыг байгуулжээ. Түүнд боловсролын хяналтын байгууллага нэгджээ.

Боловсролын эдийн засгийн шинэчлэлд тус салбарын санхүүжилт чухал үүрэгтэй байна. Боловсролын салбарын санхүүгийн эх үүсвэр нь улсын төсөв, эрдэм шинжилгээ судалгааны ажлын санхүүжилт, суралцагчдын сургалтын төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны орлого, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, бусад эх үүсвэрээс бүрдэж байна. 2006 оны боловсролын багцад 181,6 тэрбум төгрөг зарцуулжээ. Сүүлийн жилүүдэд БСШУ-ны салбарын санхүүжилт эрчимтэй өсч байна.

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг нэг суралцагчид оногдох хувьсах зардлаар тооцон улсын төсвөөс санхүүжүүлдэг журам үйлчилдэг.

Дээд боловсролын байгууллагын санхүүгийн нэг эх сурвалж нь суралцагчдын сургалтын төлбөр бөгөөд тэр суралцагчийн хувьд хувийн, хөнгөлөлттэй зээлийн, буцалтгүй тусламжийн, урамшуулалын гэсэн хэлбэрүүдтэй байна. 1993 оноос сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ эхэлсэн байна. Монгол улсын засгийн газар 1992 оны 107 тоот тогтоолоор "Мэргэжлийн сургуулийг санхүүжүүлэх журам"-ыг баталсан агаад 1993-1994 оны хичээлийн жилээс улсын захиалгаар суралцагчдын сургалтын төлбөрийг нэгдсэн санхүүжилтээр шилжүүлдэг болжээ. Ингэхдээ суралцагч, сургууль, аймаг, хотын нийгмийн бодлого хариуцсан байгууллага гэсэн гурвалсан 10 жилийн хугацаатайгаар буцаан төлөх, төлүүлэх зээлийн гэрээг байгуулжээ. Эл журмыг 1995 онд өөрчилсөн ба 1995-1996 оны хичээлийн жилээс улсын захиалгаар оюутан элсүүлэн сургах тогтолцоог өөрчлөн Засгийн газрын 1995 оны 194 дүгээр тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн сургуульд суралцагчдад хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох журам"-ын дагуу мэргэжлийн сургуульд суралцагчдад амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур буюу бага орлоготой өрхийн суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламж олгох болсон байна. Харин 1997 оноос эхлэн магадлан итгэмжлэл хийгдсэн сургуулиудад өмчийн хэлбэрийг үл харгалзан дээр өгүүлсэн зээл тусламжийг олгох болжээ.

Сургалтын төлбөрийн санхүүжилтэнд 2000 онд томоохон өөрчлөлт хийжээ. Манай засгийн газар 2000 онд 96 дугаар тогтоолоор "Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэн төлүүлэх журам", мөн онд 158 дугаар тогтоолоор "Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам"-ыг тус тус батлан гаргасан байна. Эдгээр журмаар амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрхийн суралцагчдад

⁸ Уг албыг 1995 оноос "Боловсролын улсын хяналтын алба", 1998 оноос "Гэгээрлийн улсын хяналтын алба", 2000 оноос "Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын алба" хэмээн нэрлэж байгаад салбаруудын хяналтын албыг нэгтгэн бүтцийн өөрчлөлт хийснээ УМХА-нд нэгдсэн байна.

хөнгөлөлттэй зээл олгох, харин дээрх орлого нь бүсийн түвшингээс 40 хувиас доогуур орлоготой өрхийн суралцагч, нийт малын тоог бодод шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийн суралцагч, 3 ба түүнээс дээш зэрэгцэн суралцаж буй суралцагч, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцах болсон ба сурлагын шагналын хэлбэрийг бий болгосон байна.

Суралцагч сургалтын төлбөрийн зээлийг сургуудь төгссөнөөс хойш 10 жилийн дотор төлөх ба 6 жилийн дотор төлбөл хүүгүй байх, 7 дахь жилээс арилжааны банкны жилийн дундаж хүүгээс 0,5-аар илүү хүүтэйгээр төлөх, харин мэргэжлийн дагуу төрийн байгууллагад 5 жил үр бүтээлтэй ажилласан бол зээлийн төлбөрөөс чөлөөлөөгдөхөөо заажээ.

Манай энэ журам хэрэгжиж ирснээс хойш 2004, 2008 онуудад хөнгөлттэй зээл авсан суралцагчдыг үндсэнд нь чөлөөлсөн байна.

Сургалтын төлбөр нь их дээд сургууль, коллежийн санхүүгийн орлогын гол эх сурвалж болж байгаа билээ. Жишээлбэл МУИС-ийн 2006-2007 оны хичээлийн жилийн нийт орлогын 78,1 хувийг сургалтын төлбөр бүрдүүлжээ⁹

Боловсролын удирдлагын шинэчлэл. Боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутаг дэвсгэр нэгжийн удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бүрдэж байна. Шинэчлэлийн өнөөгийн нөхцөлд шинээр гарч ирсэн удирдлагын нэгэн субъект бол цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зөвлөл, коллеж, дээд болон их сургуулийн удирдах зөвлөл юм. Энэ нь өнгөрсөн тогтолцооны үеийн дээрээс нь төвлөрүүлэн удирдах удирдлагын босоо тогтолцоог шинэчлэн өөрчлөх, төвлөрлийг сааруулах нэгэн алхам болж байна. Өнөөдөр боловсрол олгох байгууллагын удирдлага нь захиргааны, өөрийн, мэргэжил аргазүйн удирдлага гэсэн бүтэцтэй байна.

2007-2008 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээгээр 2-6 насны буюу сургуулийн өмнөх насны 224864 хүүхэд байгаагийн 130 мянга орчим нь цэцэрлэгт хамрагдаж байна¹⁰.

2007-2008 оны байдлаар манай улсын хэмжээгээр 754 ерөнхий боловсролын сургууль байгаагийн 597 нь төрийн өмчийн, 152 нь төрийн бус өмчийн, 5 нь гадаадын хөрөнгө оруулалттай сургуулиуд байгаа юм¹¹.

Дээд боловсролын салбарт төрийн болон хувийн хэвшлийн 162 их, дээд сургууль, коллежид 150 мянга гаруй, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 23 төвд 14630 оюутан суралцагч суралцаж байна¹².

Боловсролын бүх шатны байгууллагад 30 орчим мянган багш нар ажиллаж байна¹³.

Хэдийбээр манай боловсролын салбарт шинэчлэлийн үйл явц хэрэгжиж байгаа авч шийдвэрлэвэл зохих асуудлууд багагүй байгаа билээ. Боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан төлөвлөлтийн баримт бичиг болох “Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г Монгол Улсын засгийн газар 2006 онд батлан гаргасан юм. Энэхүү төлөвлөгөөнд Монгол улсын боловсролын “хэтийн зорилго нь боловсролжсон иргэний нийгмийн тасралтгүй баяжиж буй соёлоор дамжин шинжлэх ухаан тогтвортой хөгжлийн эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын найдвартай баталгааг хангахад чиглэгдэнэ” гэсэн бол “Боловсролын салбарын эрхэм зорилго нь Монгол улсын иргэн бүр хүмүүнлэг иргэний

⁹ МУИС-ийн 2006-2007 оны хичээлийн жилийн тайлан. УБ., 2007.69 дэх тал.

¹⁰ www.mecs.pmis.gov.mn

¹¹ Мөн тэнд

¹² Мөн тэнд

¹³ Мөн тэнд

ардчилсан нийгэмд чинээлэг сайхан амьдрахын тулд өөрийн чадварыг бүрэн илрүүлэн хөгжих, асуудлыг шийдвэрлэх, бүтээлчээр ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, технологи болон соёлын үнэт зүйлийг эзэмших, сонгох тэгш боломж, таатай орчинг төлөвшүүлэн байнга сайжруулахад чиглэсэн хүртээмжтэй, чанартай, үр ашигтай, тогтвортой үйлчилгээг үзүүлэхэд чиглэнэ” хэмээн уг мастер төлөвлөгөөнд тодорхойлжээ¹⁴.

Өнөөдөр энэ салбарт боловсрол, сургалтын системийг ардчилах, либеральчлах, мэдээллийн технологийг өргөн нэвтрүүлэх, боловсролын үйл явцыг хүмүүнлэг болгох, боловсролын үнэлэмжийг дээшлүүлэх, боловсролыг нээлттэй хүртээмжтэй болгох, энэ салбарын санхүүгийн эх сурвалж, төсвийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал асуудал байна.

Abstract: In this article some issues of Mongolia's education. The education sector of Mongolia is going under transformation as whole society is going too. The new transformed education system has gained some developments which were "headache" in education system during socialist regime. In XXI century the education affair of Mongolia has influenced by Globalisation that is a main issue of our discussion. The transformation of Mongolia's education system is being held heavily through following directions, such as structure and system, purpose and content, methods and technology, legislation, economy, management etc.

Ашигласан ном бүтээл, материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. "Боловсролын тухай" Монгол Улсын хууль
3. "Бага, дунд боловсролын тухай" Монгол улсын хууль
4. "Дээд боловсролын тухай" Монгол улсын хууль
5. "Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тухай" Монгол улсын хууль
6. Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
7. БНМАУ. Хууль, зарлиг, тогтоолын эмхэтгэл. УБ., 1982.
8. Боловсрол судлал. (МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг), №1(140), УБ., 1998.
9. Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр. УБ., 2001.
10. Бэгз. Н. Боловсролын хөгжлийн онол арга зүйн зарим асуудал. УБ., 1996.
11. Бэгз. Н. Глобальчлалын үеийн Монголын боловсролын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд. УБ., 2001.
12. XX зууны Монголын боловсрол судлал. УБ., 2001.

¹⁴ Монгол улсын засгийн газрын 2006 оны 8 дугаар салын 16-нд 192 тоот тогтоолоор баталсан "Монгол улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө.